



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/163

Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс,
газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, үнэлгээний аргачлалыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын үйл ажиллагааг шинэчлэн батлагдсан журмын дагуу жил бүр үнэлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т даалгасугай.

3. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан үнэлгээг тооцох, орон нутагт ил тод болгох программыг шинэчлэхийг Мэдээллийн технологийн газар /Л.Мягмарсүрэн/-т, тогтмол ажиллуулж хэвшүүлэхийг Хяналт шинжилгээ, мониторингийн хэлтэс /Б.Саранчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны А/72, 2015 оны А/147 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА



А. АРИУНЗАЯА

Үндэсний статистикийн хорооны даргын
2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
А/163.....тушаалын нэгдүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС, ГАЗРЫН
ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Статистикийн тухай хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга болон түүний статистикийн хэлтэс, газрын хүлээсэн үүргийн биелэлт, үйл ажиллагаанд Үндэсний Статистикийн хороо (цаашид ҮСХ гэх)-ноос байнгын хяналт тавих зорилгоор энэ журмыг мөрдөнө.

1.2 Энэ журмаар статистикийн хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг холбогдох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу цогцоор үнэлнэ.

1.3 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх ажлын хэсгийн дарга нь (цаашид “Ажлын хэсэг” гэх) ҮСХ-ны хяналт үнэлгээний чиг үүрэг бүхий нэгжийн дарга, нарийн бичгийн дарга нь ҮСХ-ны орон нутгийн салбар нэгжийн асуудлыг хариуцсан ажилтан, гишүүдэд ҮСХ-ны хяналт үнэлгээний чиг үүрэг бүхий нэгжийн нийт ажилтан болон шалгуур үзүүлэлт бүрт үнэлгээ өгөх ҮСХ-ны холбогдох газар, хэлтсийн ахлах статистикч/референт нар байна.

1.4 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тухайн салбарын мэдээлэл буюу асуудлыг хариуцсан ажилтан тооцож Ажлын хэсгийн гишүүн ахлах статистикч/референтэд танилцуулна.

1.5 Ажлын хэсгийн гишүүн нь үнэлгээ өгсөн ажилтны тухайн үнэлгээг гаргахад ашигласан баримт, тооцоог нягтлан шалгаж, холбогдох тайлбарын хамт тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

1.6 Ажлын хэсгийн дарга болон хяналт үнэлгээний чиг үүрэг бүхий нэгжийн ажилтнууд нь аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын үйл ажиллагааг үнэлэх явцад давхар хяналт тавина.

1.7 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь үнэлгээг нэгтгэн нийт гишүүдэд танилцуулна. Ажлын хэсгээс зөвшөөрсөн үнэлгээг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын дарга нарт урьдчилан танилцуулж зөвшилцсөн байна.

1.8 Ажлын хэсгийн дарга нь аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үнэлгээ, үр дүнг ҮСХ-ны даргын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Хоёр. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

2.1 Шалгуур үзүүлэлт (Ш)-үүд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.1.1 ҮСХ-ны зорилго, зорилтод нийцсэн аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт жигд хэрэгжүүлэх боломжтой байх;
- 2.1.2 Энгийн, тодорхой, хэмжих боломжтой байх;
- 2.1.3 Тайлан, танилцуулга баримтаар баталгаажсан байх;

2.2 Шалгуур үзүүлэлтүүдийг тооцоход баримтлах зарчмууд:

- 2.2.1 Бие даасан, хараат бус байх;
- 2.2.2 Анхдагч мэдээллийн үнэн, бодит байдлыг хангасан байх;
- 2.2.3 Анхдагч мэдээлэл, шалгуур үзүүлэлтийн үр дүн өөр хоорондоо зөрчилгүй, логик уялдаатай байх;
- 2.2.4 Анхдагч мэдээллийн давтамж, эх үүсвэр тодорхой байх;

2.3 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын тайлант жилийн ажлын үр дүнг дараах 4 бүлгийн 14 шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

Бүлэг 1. Албан ёсны статистикийн мэдээлэл

- Шалгуур 1. Мэдээний хамралт
- Шалгуур 2. Мэдээний дамжуулалт
- Шалгуур 3. Мэдээний бодит байдал, чанар
- Шалгуур 4. Хүн ам, өрхийн мэдээллийн сан
- Шалгуур 5. Бизнес регистрийн мэдээллийн сан

Бүлэг 2. Тооллого, судалгааны ажил

- Шалгуур 6. Мал тооллого
- Шалгуур 7. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
- Шалгуур 8. Ажиллах хүчний судалгаа
- Шалгуур 9. Эдийн засгийн түүвэр судалгаа

Бүлэг 3. Статистикийн сургалт, сурталчилгаа, мэдээлэл тархаалт

- Шалгуур 10. Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа
- Шалгуур 11. Мэдээлэл тархаалт, вэб баяжилт

Бүлэг 4. Дотоод ажил, санхүүгийн үйл ажиллагаа

- Шалгуур 12. Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа
- Шалгуур 13. Шилэн данс
- Шалгуур 14. Санхүүгийн үйл ажиллагаа

2.4 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт, хариуцах газар, нэгж

Код	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, нэгж	Авбал зохих оноо
Бүлэг 1. Албан ёсны статистикийн мэдээлэл			400
Ш1	Мэдээний хамралт	ЭЗСГ, ХАНСГ	100
Ш2	Мэдээний дамжуулалт	МТГ	100
Ш3	Мэдээний бодит байдал, чанар	ЭЗСГ, ХАНСГ	100
Ш4	Хүн ам, өрхийн мэдээллийн сан	ХАНСГ	50
	Баяжилт		10
	Шилжилт хөдөлгөөний бүртгэл		5
	Үзүүлэлтийн алдаа		25
	Өрхийн цэг тэмдэглэлт		10
Ш5	Бизнес регистрийн мэдээллийн сан	ЭЗСГ	50
Бүлэг 2. Тооллого, судалгааны ажил			400
Ш6	Мал тооллого	ЭЗСГ	100
	Тооллогын мэдээллийн чанар, хяналт		70
	Тооллогын мэдээллийн дамжуулалт		30
Ш7	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	ХАНСГ	100
	Түүвэр судалгааны хамралт		40
	Мэдээллийн чанар		40
	Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт		20
Ш8	Ажиллах хүчний судалгаа	Хүн ам, нийгмийн статистикийн газар (ХАНСГ)	100
	Түүвэр судалгааны хамралт		40
	Мэдээллийн чанар		40
	Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт		20
Ш9	Эдийн засгийн түүвэр судалгаа	Эдийн засгийн статистикийн газар (ЭЗСГ)	100
	Түүвэр судалгааны хамралт		40
	Мэдээллийн чанар		40
	Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт		20
Бүлэг 3. Статистикийн сургалт, сурталчилгаа, мэдээлэл тархаалт			100
Ш10	Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа	Олон нийттэй харилцах хэлтэс	50
	Нутгийн захиргааны байгууллагын ажилтанд		10
	Оюутан, сурагчдад		10
	Статистикийн мэдээлэгч нарт		10
	Хэвлэлийн бага хурал		10
	Статистикийн үйл ажиллагааны сурталчилгаа		10
Ш11	Мэдээлэл тархаалт, вэб баяжилт	Олон нийттэй харилцах хэлтэс	50
	Сар бүрийн статистикийн танилцуулга		20
	Эмхэтгэл\динамик үзүүлэлт		12
	Статистикийн жилийн танилцуулга, судалгаа		18
	Хүн ам, өрх		5
	Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт		5
	Эдийн засгийн үйл ажиллагаа		8
Бүлэг 4. Дотоод ажил, санхүүгийн үйл ажиллагаа			100
Ш12	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	ЗХНХ	20
Ш13	Шилэн данс	ХШМХ	20
Ш14	Санхүүгийн үйл ажиллагаа	Санхүүгийн хэлтэс	60
	Санхүүгийн тайлан, стандарт программын хэрэглээ		35
	Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн тайлан		5
	Анхан шатны баримтын бүрдүүлэлт		10
	Аудитын дүгнэлт		10
Бүлгүүдийн нэгдсэн дүн			1000

Жич: Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтэд үнэлгээ өгөх газар, нэгж өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд тухайн шалгуур үзүүлэлтийг хариуцах газар, нэгж үнэлгээг өгнө.

2.5 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлыг дараах томьёоны дагуу 2 оронгийн нарийвчлалаар тооцож, үнэлгээг өгнө. Үүнд:

$$\text{Үнэлгээ} = \frac{\text{Нийт авсан оноо}}{\text{Авбал зохих оноо}} \times 100\%$$

90-100 оноо авсан бол "А" буюу "Маш сайн"

80-89 оноо авсан бол "В" буюу "Сайн"

70-79 оноо авсан бол "С" буюу "Хангалттай"

60-69 оноо авсан бол "D" буюу "Дутагдалтай"

0-59 оноо авсан бол "F" буюу "Хангалтгүй"

Гурав. Шагнал урамшуулал

3.1 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрыг урамшуулах асуудлыг ҮСХ-ны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.2 Жилийн ажлын үнэлгээгээр "дутагдалтай" болон "хангалтгүй" үнэлгээ авсан аймаг, нийслэлийн хэлтэс, газрын даргад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Товчилсон үгийн тайлбар:

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЗХНХ	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
МТГ	Мэдээллийн технологийн газар
ХШМХ	Хяналт шинжилгээ, мониторингийн хэлтэс

___оОо___

Үндэсний Статистикийн хорооны даргын
2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
А/163 тушаалын хоёрдугаар хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС, ГАЗРЫН
ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Нэгдүгээр бүлэг.
Албан ёсны статистикийн мэдээлэл

(Ш1) Мэдээний хамралт: Тайлант хугацаанд мэдээнд хамрагдсан нэгжийн тоог хамрагдвал зохих нийт нэгжийн тоонд харьцуулж оноогоор илэрхийлнэ.

$$\text{Ш1} = \frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих статистик нэгжийн тоо}} \times 100$$

- Хамрагдвал зохих статистик нэгжийн тоо: Бизнес регистрийн санд бүртгэгдсэн нийт аж ахуйн нэгжийн тооноос тухайн жилд албан ёсны статистикийн сар, улирал, жилийн мэдээнд хамрагдвал зохих статистик нэгжийн жагсаалтаар тодорхойлно.
- Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо: Дээрх жагсаалтад үндэслэн мэдээнд хамруулсан статистик нэгжийн тоогоор тооцно. Хэрэв салбарын мэдээ, тайланд шинээр статистик нэгж нэмж хамруулсан бол тэдгээрийг хамрагдвал зохих болон хамруулсан нэгжийн тоонд оруулж тооцно. Шинээр мэдээнд хамруулсан ААНБ-ын мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэлтэй тулгаж шалгана.

(Ш2) Мэдээний дамжуулалт:

$$\text{Ш2} = \frac{\text{Хоцруулаагүй графикт мэдээний тоо (ХГМТ)}}{\text{Нийт графикт мэдээний тоо}} \times 100$$

Жич: Нийт графикт мэдээний тооноос шалгуур үзүүлэлт Ш6-Ш9-ийн мэдээний дамжуулалтын тоог хасаж тооцно.

ХГМТ = нийт графикт мэдээний тоо – хоцроосон графикт мэдээний тоо

“Графикт хугацаа” нь ҮСХ-ны даргын тушаалаар баталсан албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн маягтад заагдсан тэдгээрийг цуглуулах, нэгтгэх, дамжуулах хугацаа байна.

Графикт хугацаанд ирүүлсэн хэдий ч дараах зөрчил, дутагдал илэрвэл хугацаа хоцроосон гэж үзээд оноог хасч тооцно. Үүнд:

- ҮСХ-ноос боловсруулсан программаар мэдээ тайлангийн үзүүлэлтийг шивээгүй;
- Хоосон файл ирүүлэх;
- Файлын нэр, агуулга, шифр зөрүүтэй (өмнөх сарын мэдээ зэрэг) файл ирүүлэх;

- Буруу хаяг (хувийн)-аар ирүүлэх;
- Тайлант хугацаа зөрүүтэй.

(Ш3) Мэдээний бодит байдал, чанар: Мэдээний бодит байдал, чанарыг эдийн засгийн болон өрх, хүн ам, нийгмийн статистикийн мэдээ, тайланд илэрсэн алдаагаар төлөөлүүлэн хэмжинэ.

$$\text{Ш3} = 100 - \sum (\text{жин} * \text{Харгалзах алдааны дундаж хувь})$$

$$\text{Харгалзах алдааны дундаж хувь} = \sum (\text{AX}_i * \text{СНЖ}_i)$$

$$\text{Алдааны хувь } (\text{AX})_i = \frac{\text{Алдаатай мэдээлэл бүхий ААНБ-ын тоо}_i}{\text{Мэдээнд хамрагдсан ААНБ-ын тоо}_i} * 100\%$$

i – тухайн салбар

№	Алдааны төрөл	Жин
1	Үзүүлэлт дутуу нөхөх, үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн/буурсан)	0.150
2	Үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх, маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй	0.150
3	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүтээгдэхүүн үйлчилгээ, ажил мэргэжлийн болон бусад ангиллын кодыг буруу нөхөх	0.150
4	Балансын болон логик (үзүүлэлт хоорондын уялдаа)-ийн алдаа	0.250
5	Мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарлагдсан мэдээлэлд залруулга хийх	0.300

$$\text{Салбарт ногдох жин } (\text{СНЖ})_i = \frac{\text{Мэдээнд хамрагдсан ААНБ – ын тоо}_i}{\text{Нийт мэдээнд хамрагдсан ААНБ – ын тоо}}$$

(Ш4) Хүн ам, өрхийн мэдээллийн сан: Засаг захиргааны анхан шатны нэгжид хөтлөгдөж буй хүн ам, өрхийн захиргааны бүртгэлээр аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын байгуулсан ХАӨМС-гийн ажлын үр дүнг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ. Үүнд:

$$\text{Ш4} = \text{Баяжилт(Б + ШХБ)} + \text{Чанар(үзүүлэлтийн алдаа + өрхийн цэг тэмдэглэлт)}$$

1. Баяжилт, шилжих хөдөлгөөний бүртгэл – 15.0 оноо

Аймгийн сум, нийслэлийн хорооны Засаг даргын захиргааны бүртгэлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын (УБАЭТЗТБ)-ын улсын бүртгэлтэй тулгаж дараах томъёогоор оноог тооцно.

$$\checkmark \text{ Баяжилт (Б) -10.0 оноо: } \quad \text{Б} = 10 * \frac{\left(\frac{\text{ХАӨМС-ийн төрөлт}}{\text{УБАЭТЗТБ-ын төрөлт}} + \frac{\text{ХАӨМС-ийн нас баралт}}{\text{УБАЭТЗТБ-ын нас баралт}} \right)}{2}$$

✓ Шилжих хөдөлгөөний бүртгэл (ШХБ) – 5.0 оноо:

$$\text{ШХБ} = 5 * \left(1 - \frac{\text{ХАӨМС – д шилжилт нь баталгаажаагүй хүн ам}}{\text{Шилжих хөдөлгөөнийг нь ХАӨМС – д бүртгэх хүн ам}} \right)$$

Аймаг, нийслэлийн түвшинд ШХБ-ийг тооцно. Үүнд:

- ХАӨМС-д баталгаажаагүй хүн ам: Аймаг/нийслэлээс албан ёсоор шилжүүлгээ хийлгэсэн боловч ХАӨМС-д шилжих хөдөлгөөн баталгаажуулаагүй хүн ам.

- Шилжих хөдөлгөөнийг нь ХАӨМС-д бүртгэх хүн ам: албан ёсоор шилжин явсан бүх хүн ам байна.

2. Чанар – 35.0 оноо

✓ Үзүүлэлтийн алдаа – 25.0 оноо

$$\text{Хүн амын үзүүлэлт} = 15 * \left(1 - \frac{\text{Хүн амын үзүүлэлтийн алдааны тоо}}{\text{Хүн амын нийт үзүүлэлтийн тоо}} \right)$$

Хүн амын нийт үзүүлэлтийн тоо = Нэг хүнээс авах үзүүлэлтийн тоо * Хүн амын нийт тоо

- Нэг хүнд ногдох үзүүлэлтийн тоог ХАӨМС-гийн хүн амын үзүүлэлтээр тооцно.

$$\text{Өрхийн үзүүлэлт} = 10 * \left(1 - \frac{\text{Өрхийн үзүүлэлтийн алдааны тоо}}{\text{Өрхийн нийт үзүүлэлтийн тоо}} \right)$$

Өрхийн нийт үзүүлэлтийн тоо

= Нэг өрхөөс авах үзүүлэлтийн тоо * Өрхийн нийт тоо

- Нэг өрхөд ногдох өрхийн үзүүлэлтийн тоог ХАӨМС-гийн орон сууцны нөхцөл, өрхийн аж ахуйн үзүүлэлтийн нийлбэрээр тооцно.

✓ Өрхийн цэг тэмдэглэлт - 10.0 оноо

ХАӨМС-гийн газрын зурагт өрхийн цэг тэмдэглэлтийг дараах томъёогоор бодож гаргана.

$$\text{Цэг тэмдэглэлт} = 10 * \left(1 - \frac{\text{ХАӨМС – нд цэг тэмдэглэгдээгүй өрхийн тоо}}{\text{Өрхийн нийт тоо}} \right)$$

(Ш5) Бизнес регистрийн мэдээллийн сан:

$$\text{Ш5} = \frac{\text{Жилийн эцсийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны мэдээний хүрээнд хамрагдсан ААНБ – ын тоо}}{\text{Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан өгсөн ААНБ – ын тоо}} * 50$$

Жич: Төрийн бус байгууллагыг оруулахгүй.

Хоёрдугаар бүлэг.

Тооллого, судалгааны ажлын үр дүн

(Ш6) Мал тооллого: Жилийн эцсийн мал тооллогын ажлыг дараах 2 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

$$\text{Ш6} = \text{Чанар, хяналт (1)} + \text{Дамжуулалт(2)}$$

1. Тооллогын мэдээллийн чанар, хяналт – 70.0 оноо

$$\text{Чанар} = 50 * \left[1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}}{\text{Нийт үзүүлэлтийн тоо}} \right]$$

Нийт үзүүлэлтийн тоо = Хамрагдвал зохих өрхийн тоо * Нэг өрхөөс авах үзүүлэлтийн тоо

Алдааны тоо нь хамрагдвал зохих өрх, ААНБ-ын тооноос илүү гарсан тохиолдолд чанарын оноог 0-ээр тооцно.

- Логик (үзүүлэлт хоорондын уялдаа), балансын алдаа
- Үзүүлэлт дутуу нөхөх
- Үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх
- Үзүүлэлтийг маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй
- Үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (ессөн/буурсан)
- Ангиллын кодыг буруу нөхөх
- Том малын зүй бус хорогдол, мал төллөлт, төл бойжилтын явцын мэдээнээс 15 хувиас илүү зөрүүтэй /байгалийн гамшигт үзэгдэл болон мал амьтны гаралтай халдварт өвчний шалтгаанаас бусад тохиолдолд/
- Малтай өрх болон малчин өрхийн тоо өмнөх оныхоос үндэслэлгүй өөрчлөгдсөн.
- Мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарлагдсан мэдээлэлд залруулга хийх

Тооллогын хяналт – 20.0 оноо

Мал тооллогоор тоологдсон нийт өрх, ААНБ болон хяналтын тооллогод хамрагдсан өрх, ААНБ-ын хамралтыг харгалзан дараах байдлаар үнэлнэ.

Хяналтын тооллогыг нийт тооллогод хамрагдсан өрх, ААНБ-ын 10 хувьтай тэнцэх хэсэгт хийнэ.

Үүнд:

$$\text{Хамралт} = \frac{\text{Хяналтын тооллогод хамрагдсан өрх, ААНБ – ын тоо}}{\text{Хяналтын тооллогод хамрагдах ёстой өрх, ААНБ – ын тоо}} \times 20$$

2. Тооллогын мэдээллийн дамжуулалт – 30.0 оноо

Дамжуулалт = 30 – Хугацаа хоцроосон хоногийн тоо * 8

- Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд шууд 0.0 оноо өгнө.

(Ш7) Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа: Өрхийн нийгэм, эдийн засгийн үнэлгээг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

$$\text{Ш7} = \text{Хамралт (1)} + \text{Чанар (2)} + \text{Дамжуулалт(3)}$$

1. Түүвэр судалгааны хамралт – 40.0 оноо

$$\text{Хамралт} = 40 - \left(\frac{\text{Нөөц өрхийн тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right) - \text{СХӨТ}$$

СХӨТ- Судалгаанд хамруулаагүй өрхийн тоо

2. Мэдээллийн чанар – 40.0 оноо

$$\text{Чанар} = 40 * \left[1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}}{\text{Нийт үзүүлэлтийн тоо}} \right]$$

Нийт үзүүлэлтийн тоо = Хамрагдвал зохих өрхийн тоо * Нэг өрхөөс авах үзүүлэлтийн тоо

3. Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт -20.0 оноо

Дамжуулалт = 20 – Хугацаа хоцроосон хоногийн тоо * 5

- Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд шууд 0.0 оноо өгнө.

(Ш8) Ажиллах хүчний судалгаа: Дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ.

$$\text{Ш8} = \text{Хамралт (1)} + \text{Чанар (2)} + \text{Дамжуулалт(3)}$$

1. Түүвэр судалгааны хамралт – 40.0 оноо

$$\text{Хамралт} = 40 - \left(\frac{\text{Нөөц өрхийн тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right) - \text{СХӨТ}$$

- СХӨТ- Судалгаанд хамруулаагүй өрхийн тоо

2. Мэдээллийн чанар – 40.0 оноо

$$\text{Чанар} = 40 * \left[1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}}{\text{Нийт үзүүлэлтийн тоо}} \right]$$

Нийт үзүүлэлтийн тоо

$$= \text{Хамрагдвал зохих өрхийн тоо} * \text{Нэг өрхөөс авах үзүүлэлтийн тоо}$$

3. Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт -20.0 оноо

Дамжуулалт = 20 – Хугацаа хоцроосон хоногийн тоо * 5

- Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд шууд 0.0 оноо өгнө.

(Ш9) Эдийн засгийн түүвэр судалгаа: Тухайн жилд явагдсан судалгаануудын үнэлгээний дунджаар тооцно. Судалгааг өрхөд суурилсан, ААНБ-ын түүвэр судалгаа гэж ангилж дүгнэнэ.

1. Өрхөд суурилсан эдийн засгийн түүвэр судалгааны хувьд ӨНЭЗС-тай адил зарчмаар дүгнэнэ.

2. ААНБ-ын түүвэр судалгааг дараах байдлаар дүгнэнэ.

Эдийн засгийн түүвэр судалгааны ажлыг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

$$\text{Ш9} = \text{Хамралт (1)} + \text{Мэдээллийн чанар(2)} + \text{Мэдээлэл дамжуулалт(3)}$$

1. Түүвэр судалгааны хамралт – 40.0 оноо

$$\text{Хамралт} = 40 * \frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих нийт статистик нэгжийн тоо}}$$

2. Мэдээллийн чанар – 40.0 оноо (Шалгуур үзүүлэлт -3 -тай адил дүгнэнэ.)

3. Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт – 20.0 оноо

Дамжуулалт = 20 – Хугацаа хоцроосон хоногийн тоо * 5

- Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд шууд 0.0 оноо өгнө.

Гуравдугаар бүлэг.
Статистикийн сургалт, сурталчилгаа, мэдээлэл тархаалт

(Ш10) Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа: $Ш10 = Ш10.1 + Ш10.2$

1. Сургалтын үйл ажиллагааг дараах томъёоны дагуу тооцно.

$Ш10.1 = БХСС + ИЕС + ААНС$

БХСС - Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудад буюу баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт

ИЕС - Оюутан, сурагчдад зориулсан сургалтад тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын төв, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хичээлийг оруулж тооцно.

ААНС - Статистикийн анхдагч мэдээллийг бүрдүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт

А) Баг, хороо, сум, дүүргийн статистикийн мэдээ хариуцсан (баг, хорооны Засаг дарга, сумын төрийн сангийн төлөөлөгч зэрэг) ажилтнуудад зориулсан сургалтыг жил бүр ээлжлэн зохион байгуулж, нийт хичнээн баг, хороо, сум, дүүргийн статистикийн мэдээ хариуцсан ажилтнууд хамрагдсан талаарх бүртгэлийг хийж, заасан хичээлийн материалыг хавсаргасан илтгэх хуудсыг ирүүлнэ. (Сургалт зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногт ирүүлэх)

Ирц: хамралт 0.0–5.0 оноо, (хамралтыг тухайн аймгийн баг, хороо, сумдын тоогоор тооцно)

Хичээлийн материал: сэдэв 0.0 - 5.0 оноо

№	Сэдвийн шалгуур үзүүлэлт	Оноо
1	Албан ёсны статистикийн үйл ажиллагаа	0.8
2	Хүн ам, нийгмийн статистикийн мэдээ гаргах аргачлал, заавар	1.0
3	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ, программ	1.0
4	Монгол Улсын Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баг, хороо, сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудын үүрэг, оролцоо	0.5
5	Салбарын статистикийн мэдээ, тайлан гаргах аргачлал заавар	0.7
6	Мал тооллогын мэдээллийн сангийн хэрэглээ, программ	1.0

Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

Б) Статистикийн хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Их, дээд сургуулийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад, статистикийн анхдагч мэдээллийг бүрдүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад сургалтыг зохион байгуулж, хамрагдсан оролцогчдын тоог авч, статистикийн бүтээгдэхүүн, сурталчилгааны материал тарааж, хамрагдсан оролцогчдоос сургалтын үнэлгээний асуулга авч, заасан хичээлийн материал, асуулгын дүн, үйл явцын зургийг хавсаргасан илтгэх хуудсыг ирүүлнэ. (Сургалт зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногт ирүүлэх)

Тайланд үйл явцыг харуулсан зураг, хамралт, тараасан материал, асуулгын дүнг тусгах бөгөөд 0.0-10.0 оноо өгнө.

Дээрх 2 төрлийн сургалт бүрт 10.0 оноо өгнө. Дараах шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Тухайн сургалтын хичээлийн сэдэв	5.0
2	Оролцогчдын хамралт	2.0
3	Сургалтад тараасан материал	1.0
4	Оролцогчдоос авсан санал асуулгын дүн	1.0
5	Сургалтын үйл явцын зураг	1.0

✓ Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

2. Сурталчилгааны үйл ажиллагааг дараах томъёоны дагуу тооцно.

$$\text{Ш10.2} = \text{ХБХ} + \text{ТСС}$$

ХБХ - Хэвлэлийн бага хурал

ТСС – Тооллого, судалгааны сурталчилгаа

А) Сар бүр статистикийн мэдээллээр хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, сонин хэвлэлд нийтлүүлсэн материалыг хавсаргасан тайланг улирал бүр ирүүлнэ. ҮСХ-ны албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны дүнг тархаах хуваарьт заасан хэвлэлийн бага хурлыг товлосон өдөрт орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

$$\text{ХБХ} = \text{Хэвлэлийн бага хурал хийсэн тоо} * \frac{10.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

Жич: НСГ-ын хувьд 10 оноог шууд өгнө. Харин орон нутгийн телевизийн студи байхгүй аймгийн хувьд хэвлэлийн бага хурлын оноог сонин, хэвлэлд сурталчилсан мэдээллийг харгалзан үнэлнэ.

Б) Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйл, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу ҮСХ-ноос тухайн жилд зохион байгуулж байгаа тооллого, судалгааны талаар улирал тутам мэдээлэл бэлтгэж, сурталчлах бөгөөд тайланг ажлын 3 хоногт багтаан ҮСХ-ны маркетинг, сурталчилгаа хариуцсан нэгжид ирүүлнэ.

$$\text{ТСС} = \text{Тооллого судалгааны ажлыг сурталчилсан тоо} * \frac{10.0 \text{ оноо}}{4 \text{ (улирал)}}$$

(Ш11) Мэдээлэл тархаалт, вэб баяжилт: Дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

1. Сар бүрийн статистикийн танилцуулга -20.0 оноо

1.1 Байгууллагын танилцуулга – 2.0 оноо

Тухайн газар, хэлтэс өөрийн байгууллагын танилцуулга болон түүхэн замналыг тухайн жилдээ 1-р улиралд багтаан шинэчилсэн бол 2 оноо өгнө.

1.2 Бюллетень, танилцуулга - 12.0 оноо

Сарын бюллетень, танилцуулгыг дараа сарын 15-ны дотор газар, хэлтсийн вэб хуудаст оруулсан байна. Өмнөх оны эцсийн болон тайлант оны эхний 11 сарын

байдлаар нийт 12 удаа бюллетень, танилцуулгыг бэлтгэн байршуулсан байна.

$$\text{БюТЭ} = \text{Бюллетень, танилцуулга вэб сайтад байршуулсан удаа} * \frac{12.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

1.3 Шинэ мэдээ, мэдээлэл – 6.0 оноо

Сарын мэдээллээр хийх хэвлэлийн бага хурлын илтгэлийн файлыг сар бүрийн 15-ны дотор вэб хуудсандаа оруулсан байна. Өмнөх оны жилийн эцсийн болон тайлант оны эхний 11 сарын байдлаар нийт 12 удаа илтгэл бэлтгэн байршуулсан байна.

$$\text{ШММ} = \text{Бага хурлын илтгэлийн файлыг байршуулсан удаа} * \frac{6.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

Сарын мэдээллээр хийх хэвлэлийн бага хурлын Power Point танилцуулгын загварыг www.1212.mn сайтын “Сарын мэдээний презентаци” булангаас ашиглана.

2. Эмхэтгэл, динамик үзүүлэлт -12.0 оноо

2.1 Жилийн эмхэтгэл -2.0 оноо

Жилийн эмхэтгэлийг 6-р сарын 30-ны дотор газар, хэлтсийнхээ вэб хуудсанд оруулсан байна.

2.2 Аймаг, нийслэлийн статистикийн үзүүлэлт - 10.0 оноо

Статистикийн хэлтэс, газар нь аймаг, нийслэлийн хөгжлийн үндсэн болон статистикийн эмхэтгэлийн үзүүлэлтээр засаг захиргааны нэгжээр динамик бүрдүүлсэн байна. Динамик нь тухайн засаг захиргааны нэгж байгуулагдсан оноос эхэлсэн байх бөгөөд ҮСХ-ноос тухайн үзүүлэлтийг зарлахыг зөвшөөрснөөс хойш 10 хоногийн дотор шинэчлэн баяжуулна.

Хугацаандаа	5.0 оноо
Хугацаанаас хойш	2.5 оноо
Бүрэн биш	0 оноо

Аймаг, нийслэлийн статистикийн мэдээллээр 5-аас доошгүй хугацааг (сар, улирал, жил гэх мэт) хамруулан инфографик бүхий мэдээлэл бэлтгэн улирал тутам оруулах.

5, түүнээс дээш салбар хамруулсан бол	5.0 оноо
4 салбар	4.0 оноо
3 салбар	3.0 оноо
2 салбар	2.0 оноо
1 салбар	1.0 оноо

• Статистикийн мэдээ, мэдээллийг боловсруулж, тархаахдаа ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 1/137 тоот тушаалаар баталсан салбарын логог ашиглана.

3. Статистикийн жилийн танилцуулга, судалгаа -18.0 оноо

Статистикийн хэлтэс, газар нь дараах ерөнхий сэдвийн хүрээнд боловсруулж бэлтгэн жил бүрийн 07 сарын 01-ний өдрийн дотор вэб хуудсандаа байршуулсан байна. Үүнд:

- 3.1 “Аймаг, нийслэлийн хүн ам, өрх” - 5.0 оноо
- 3.2 “Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт” - 5.0 оноо
- 3.3 Эдийн засгийн үйл ажиллагаа - 8.0 оноо
- Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга - 5.0 оноо
- Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга -3.0 оноо

Дөрөвдүгээр бүлэг.
Дотоод ажил, санхүүгийн үйл ажиллагаа

(Ш12) Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа:

Хэлтэс, газар нь тухайн жилийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга буюу 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалтыг шинэчлэн баталгаажуулж, тухайн оны 01 дүгээр улиралд багтаан ҮСХ-ны архив хариуцсан ажилтан (тухайн цаг үед түүний ажлыг орлох)-д файлаар ирүүлсэн байна.

Хугацаандаа ирүүлсэн:

- Хөтлөх хэргийн нэргийн жагсаалт -10 оноо
- Хадгаламжийн нэгжийн жагсаалт -10 оноо

Хугацаа хоцроосон бол хоцроосон хугацаанаас хамаарч 0-10 оноо өгнө.

Үүнд:

- 1 сар хүртэл хоцроосон бол -10 оноо
- 1-2 сар хүртэл хоцроосон бол -5 оноо
- 2, түүнээс дээш сар хоцроосон болон ирүүлээгүй тохиолдолд -0 оноо

(Ш13) Шилэн данс: Цахим хуудсанд мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулсан байдлыг харгалзан дараах оноог өгнө. Үүнд:

- Мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол -1 оноо
- Мэдээллийг хугацаа хоцроосон бол -0.5 оноо
- Мэдээлэл шаардлага хангаагүй болон байршуулаагүй бол -0 оноо

$$\text{ШДХХ} = \frac{\text{ХБМТТ} * 1 + \text{ХХМТТ} * 0.5}{\text{Байршуулах мэдээ, тайлангийн тоо}} * 20$$

ХБМТТ - хугацаанд нь байршуулсан мэдээ, тайлангийн тоо

ХХМТТ –хугацаа хоцроосон мэдээ,тайлангийн тоо

(Ш14) Санхүүгийн үйл ажиллагаа: Төсөвт хөрөнгийн зарцуулалт, тайлагналт, аудитын дүгнэлтийг харгалзан дүгнэнэ.

1. Санхүүгийн тайлан, стандарт программын хэрэглээ -35 оноо

1.1 Санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, хуулийн хугацаанд ирүүлсэн байдлыг харгалзан -20.0 оноо

№	Шалгуур үзүүлэлт	Иж бүрэн, хугацаандаа, үнэн зөв	Алдаатай тайлан	Хугацаа хожим-дуулсан, тайлан гаргаагүй
1	Санхүүгийн байдлын тайлан	3	1	0
2	Санхүүгийн үр дүнгийн тайлан	3	1	0
3	Өмчийн өөрчлөлтийн тайлан	3	1	0
4	Мөнгөн гүйлгээний тайлан	3	1	0
5	Шалгах баланс /аккурэль болон мөнгөн суурьт/	3	1	0
6	Төсвийн гүйцэтгэлийн тайлан /цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын ангиллаар/	3	1	0
7	Тодруулгат тайлан, (Үндсэн хөрөнгө, бараа материалл, өглөг, авлага, орон тоо, цалингийн сангийн тайлан)	2	1	0

Санхүүгийн стандарт программын хэрэглээ: Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэй санхүүгийн программаар өмнөх оны жилийн эцсийн болон тайлант оны 2 улирлын тайланг гаргаж ирүүлсэн бол 3.0 оноо, программ ашиглаагүй бол 0 оноо өгнө.

1.2 Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг үнэн зөв, хугацаанд нь ирүүлсэн сар бүрт 1 оноо өгнө.

2. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн тайлан: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлт, жилийн эцсийн тооллогын бүртгэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт/-г дараа оны 02 сарын 25-ны дотор ҮСХ-ны санхүүгийн хэлтэст ирүүлсэн тохиолдолд 5.0 оноо өгнө.

3. Аудитын дүгнэлт: Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь аудитын зөрчилгүй дүгнэлт авсан бол 10.0 оноо өгнө.

4. Судалгааны зардлын зарцуулалтын тайлагналт, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харгалзан 10.0 оноо өгнө. Тухайлбал:

- Тайлагналт хугацаандаа, анхан шатны баримтын бүрдэл бүрэн бол 10 оноо
- Анхан шатны баримтын бүрдэл бүрэн боловч хугацаа хоцроосон бол 8 оноо
- АШБ-ын бүрдэл дутуу, хугацаа хоцорсон бол 0 оноо өгнө.

___оОо___